



## ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ханбогд хот тохижилт ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ӨМА-2026/017/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Өмнөговь аймаг 2026 он</p>	<p>Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: <a href="mailto:usukhbayarts@audit.gov.mn">usukhbayarts@audit.gov.mn</a> Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: <a href="mailto:khongorzult@audit.gov.mn">khongorzult@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Г.Шижирболд Утас: 70533552 Цахим хаяг: <a href="mailto:umnugovi@audit.gov.mn">umnugovi@audit.gov.mn</a> Азуре хүлэг аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал: Г.Мөнхбаяр Утас: 70110090 Цахим хаяг: <a href="mailto:audit@azure.mn">audit@azure.mn</a></p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.03.16 № 301

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХАНБОГД ХОТ ТОХИЖИЛТ  
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ  
О.АНГАРАГ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Ханбогд хот тохижилт ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг, бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Өмнөговь аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй "Нутгийн дэм" хөтөлбөрт хамрагдаж, байгууллагын албан хаагчдад нийт 159,986.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

**Аудитын гол асуудал**

Ханбогд сумын төсвийн хөрөнгө оруулалтаар 1,588,483.6 мянган төгрөгийн автомашин, засварын граж барих, ногоон байгууламжийн хашаа барих, хог хаягдлын ландфиллын цэг байгуулах ажлууд хийгдсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тус үйлдвэрийн газар нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлтэд бусад мэдээлэл хэсэгт тусгагдсан асуудал нь хамаарахгүй болно.

4626050436

F-12.Бичиг хэрэг/2026/он/СТА-- дүгнэлт/Төсөл Дорж

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>	-	-
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	-	-
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	634,447,441.06	711,734,628.68
1.1.2	Дансны авлага	292,941,388.00	4,620,000.00
1.1.3	Татвар, НДШ - ийн авлага	-	-
1.1.4	Бусад авлага	-	-
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	151,555,271.31	173,056,998.49
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/Тооцоо	-	-
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>1,078,944,100.37</b>	<b>889,411,627.17</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	2,152,603,766.41	3,390,676,218.53
1.2.2	Биет бус хөрөнгө	-	-
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>2,152,603,766.41</b>	<b>3,390,676,218.53</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,231,547,866.78</b>	<b>4,280,087,845.70</b>
<b>2</b>	<b>Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч</b>	-	-
<b>2.1</b>	<b>ӨР ТӨЛБӨР</b>	-	-
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>	-	-
2.1.1.1	Дансны өглөг	7,400,000.01	-
2.1.1.2	Цалингийн өглөг	-	-
2.1.1.4	НДШ - ийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	290,644,285.00	-
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>298,824,015.51</b>	<b>179,145.16</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>	-	-
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	-
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	-	-
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>298,824,015.51</b>	<b>179,145.16</b>
<b>2.3</b>	<b>Эзэмшигчдийн өмч</b>	-	-
2.3.1	Өмч: - төрийн	2,290,642,193.50	3,894,475,775.50
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	8,989,041.82	8,989,041.82
2.3.9	Хуримтлагдсан ашиг	633,092,615.96	376,443,883.22
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	2,932,723,851.28	4,279,908,700.54
<b>2.4</b>	<b>Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн</b>	<b>3,231,547,866.78</b>	<b>4,280,087,845.70</b>

Ханбогд хот тохижилт ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	2,192,602,729.69	2,262,368,129.96
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	107,999,250.00
<b>3</b>	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>2,192,602,729.69</b>	<b>2,154,368,879.96</b>
4	Түрээсийн орлого	56,723,636.36	65,654,545.45
8	Бусад орлого	-	-
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	170,371,242.33	563,618,321.09
11	Санхүүгийн зардал	667,566.22	674,406.09
12	Бусад зардал	1,674,504,476.36	1,931,629,430.98
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>403,783,081.15</b>	<b>(275,898,732.74)</b>
19	Орлогын татварын зардал	40,378,308.12	-
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>363,404,773.03</b>	<b>(275,898,732.74)</b>
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал</b>	<b>363,404,773.03</b>	<b>(275,898,732.74)</b>
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>	<b>363,404,773.03</b>	<b>(275,898,732.74)</b>
	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээ	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
<b>2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,588,427,530.50</b>	<b>8,989,041.83</b>	<b>250,643,288.80</b>	<b>1,848,059,861.12</b>
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	702,214,663.00	-	19,044,554.13	721,259,217.13
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>2,290,642,193.50</b>	<b>-</b>	<b>269,687,842.93</b>	<b>2,569,319,078.25</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	363,404,773.03	363,404,773.03
<b>2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>2,290,642,193.50</b>	<b>8,989,041.83</b>	<b>633,092,615.96</b>	<b>2,932,723,851.28</b>
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	19,250,000.00	19,250,000.00
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>652,342,615.96</b>	<b>2,951,973,851.28</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(275,898,732.74)	(275,898,732.74)
Бусад дэлгэрэнгүй орлого	15,350,000.00	-	-	15,350,000.00
Өмчид гарсан өөрчлөлт	1,588,483,582.00	-	-	1,588,483,582.00
<b>2025 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл</b>	<b>3,894,475,775.50</b>	<b>8,989,041.82</b>	<b>376,443,883.22</b>	<b>4,279,908,700.54</b>

Ханбогд хот тохижилт ОНӨААТҮГ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>2,468,177,037.74</b>	<b>2,514,231,108.39</b>
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,004,736,255.21	1,309,546,990.90
	Бусад мөнгөн орлого	463,440,782.53	1,204,684,117.49
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлага (-)</b>	<b>1,833,858,422.51</b>	<b>2,365,820,423.06</b>
	Ажиллагчдад төлсөн	486,565,372.00	838,301,711.34
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	122,988,113.35	175,551,847.36
	Бараа материал худалдан авахад төлсөн	309,943,870.00	259,462,921.40
	Ашиглалтын зардалд төлсөн	247,991,264.08	349,925,573.28
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	335,837,628.00	205,104,010.00
	Хүүний төлбөрт төлсөн	667,566.22	674,406.09
	Татварын байгууллагад төлсөн	299,179,808.81	240,634,234.44
	Даатгалын төлбөрт төлсөн	1,165,500.05	1,798,605.00
	Бусад мөнгөн зарлага	29,519,300.00	294,367,114.15
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>634,318,615.23</b>	<b>148,410,685.33</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	-	-
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>5,544,662.10</b>	<b>5,108,102.29</b>
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
	Хүлээн авсан хүүний орлого	5,544,662.10	5,108,102.29
	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>183,378,000.00</b>	<b>76,231,600.00</b>
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	183,378,000.00	76,231,600.00
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>177,833,337.90</b>	<b>(71,123,497.71)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	-	-
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	-	-
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
	Төрөл бүрийн хандив	-	-
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	-	-
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	-	-
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>456,485,277.33</b>	<b>77,287,187.62</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>177,962,163.73</b>	<b>634,447,441.06</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>634,447,441.06</b>	<b>711,734,628.68</b>

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2024 оны гүйцэтгэл	2025 он			
			Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Борлуулалтын орлого (цэвэр)	2,249,326.4	2,816,230.0	2,328,022.7	(488,207.3)	82.7
2	Борлуулалтын өртөг	-	-	-	-	-
3	Нийт ашиг (алдагдал)	2,249,326.4	2,816,230.0	2,328,022.7	(488,207.3)	82.7
4	Үйл ажиллагааны зардал	1,845,543.3	2,807,740.7	2,603,921.4	(203,819.3)	92.7
5	Үндсэн үйл ажиллагааны ашиг алдагдал	403,783.1	8,489.3	(275,898.7)	(284,388.1)	(3,250.0)
9	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	403,783.1	8,489.3	(275,898.7)	(284,388.1)	(3,250.0)
10	Орлогын татварын зардал	40,378.3	848.9	-	(848.9)	-
11	Тайланд үеийн цэвэр ашиг ( алдагдал)	363,404.8	7,640.4	(275,898.7)	(283,539.1)	(3,611.1)

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 8.9 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад 8.9 сая төгрөгийн алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

- 2025 оны "Өмчийн өөрчлөлтийн тайлан"-ийн эхний үлдэгдэл 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн эцсийн үлдэгдлээс зөрүүтэй;
- Байгууллагын үйл ажиллагаанд 1 жилээс дээш хугацаанд ашиглагдах үндсэн хөрөнгийн шинжтэй 8.9 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилгыг бараа материалаар бүртгэсэн;
- "Өмчийн өөрчлөлтийн тайлан"-ийн тайлант үеийн цэвэр ашиг алдагдлын дүнг зөрүүтэй тайлагнасан байна.

Аудитаар 1 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 33.7 сая төгрөгөөр бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй.

### 5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага тогтоогдоогүй.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн элэгдэлтэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 83 ширхэг үндсэн хөрөнгийн үнэлгээг хийж, ашиглах хугацаа, өртгийг шинэчлэн тогтоогдоогүй байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 20 дугаар зүйл 20.2 "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ" заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна" заалт, Сангийн сайдын 2014 оны 249 тоот тушаалд "Хөрөнгөнд холбогдох эдийн засгийн ирээдүйн өгөөж буюу үйлчилгээний чадавхыг тухайн байгууллага хүртэх магадлалтай ба хөрөнгийн өртөг эсвэл бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжтой тохиолдолд үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэнэ" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгссөн зөвлөмж: Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ нөхсөн боловч үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнийг нягтлан бодох бүртгэлийн зорилгоор тодорхойлж, холбогдох бүртгэлийг НББОУС 16 Үндсэн хөрөнгөд заасны дагуу хэрэгжүүлэх;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ****Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй Орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2025 оны "Өмчийн өөрчлөлтийн тайлан"-ийн эхний үлдэгдэл 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн эцсийн үлдэгдлээс зөрүүтэй.	1	-	-	-	1	-	1	-	-	-	-	-
2	Байгууллагын үйл ажиллагаанд 1 жилээс дээш хугацаанд ашиглагдах үндсэн хөрөнгийн шинжтэй 8,940.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилгыг бараа материалаар бүртгэсэн.	1	8,940.0	-	-	1	8,940.0	1	8,940.0	-	-	-	-
3	"Өмчийн өөрчлөлтийн тайлан"-ийн тайлант үеийн цэвэр ашиг алдагдлын дүнг зөрүүтэй тайлагнасан.	1	-	-	-	1	-	1	-	-	-	-	-
	<b>Дүн</b>	<b>3</b>	<b>8,940.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>8,940.0</b>	<b>3</b>	<b>8,940.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 83 ширхэг үндсэн хөрөнгүүдийн үнэлгээг хийж, ашиглах хугацаа, өртгийг шинэчлэн тогтоогоогүй	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
	<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Байгууллагын 10 жилийн ойн арга хэмжээнд төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж 60,316.0 мянган төгрөгийг зарцуулсан	1	60,316.0	-	-	1	60,316.0	-	-
2	Шилэн дансны мэдээллийг тулган баталгаажуулахад цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 2 гүйлгээ буюу 10,864.0 мянган төгрөгийг мэдээлээгүй	1	10,864.0	-	-	-	-	1	10,864.0
	<b>Дүн</b>	<b>2</b>	<b>71,180.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>60,316.0</b>	<b>1</b>	<b>10,864.0</b>